222

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМД

2026.06.22

Гомдол гаргах тухай

Э.Дэлгэрмаагийн нэхэмжлэлтэй Налайх дүүргийн эрүүл мэндийн төвд холбогдох жирэмсний болон амаржсаны тэтгэмжид 11,145,481 төгрөг гаргуулах нэхэмжлэлтэй иргэний хэргийг хянан хэлэлцсэн Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 210/МА2026/01264 дугаар магадлалыг эс зөвшөөрч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1 болон 172.2.4-т заасныг удирдлага болгон хяналтын журмаар гомдол гаргаж байна.

Гомдлын агуулга:

Нэхэмжлэгч Э.Дэлгэрмаа нь Налайх дүүргийн эрүүл мэндийн төвд 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн хөдөлмөрийн гэрээ байгуулан яаралтай тусламжийн тасагт сувилагчаар ажиллаж байгаад 2025 оны 11 сарын 03-ны өдрөөс жирэмсний болон амаржсаны амралтаа авч, Нийгмийн даатгалын даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ гаргасан боловч ажил олгогч нь нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан хугацаанд төлж барагдуулаагүй, өр төлбөртэй байсны улмаас хуулиар олгогдсон тэтгэмж авах эрх зөрчигдсөн юм. Улмаар Нийгмийн даатгалын өрөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.6 дахь хэсэгт *"Ажил олгогчийн бүрүүгаас нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөөгүй, дутуу, эсхүл хугацаа хожимдож төлөгдсөн, шимтгэл төлөлтийн тайланг ирүүлээгүй, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авах баримт бичгийг даатгуулагчид болон нийгмийн даатгалын байгууллагад хуульд заасан хугацаанд гаргаж өгөөгүйн улмаас тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг авч чадаагүй, эсхүл хугацаандаа бүрэн авааагүй бол учирсан хохирол, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхэд гарсан зардлыг ажил олгогчоор төлүүлэх эрхтэй"* гэж заасныг үндэслэн нэхэмжлэл гаргасан.

Багахангай, Налайх дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 193/Ш32026/00131 дугаартай Иргэний хэрэг үүсгэх тухай захирамжаар нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэл нь хуульд заасан бүрдүүлбэрийн шаардлага хангасан, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13,14 дүгээр зүйлд заасан хэргийн болон шүүхийн харьяаллыг зөрчөөгүй тул нэхэмжлэлийг хүлээн авч иргэний хэргийг үүсгэх үндэслэлтэй байна гэж иргэний хэрэг үүсгэсэн (ХХ-ийн 18 талд) ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өрдийн журмаар явуулж тус шүүхийн 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 193/ШШ2026/00709 дугаартай шийдвэрээр хариуцагчаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж болох 11,145,481 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгч Э.Дэлгэрмаад олгож, нэхэмжлэлээс үлдэх нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байдаг

Гэтэл Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 210/МА2026/01264 дугаар магадлалаар хариуцагчийн гаргасан давж заалдах гомдлын дагуу хэргийг хянан хэлэлцэж анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн юм. Давж заалдах шатны шүүхийн магадлалын үндэслэл нь "... ИХШХШ тухай хуулийн 75^1 дүгээр зүйлийн 75^1.1.4 дэх хэсэгт

хамаарах тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлэх нэхэмжлэлийг хүлээн авч, ердийн журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн байх тул мөн хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, 117 дугаар зүйлийн 117.1-д зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгоно" гэж дүгнэсэн байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75[1].1 дэх хэсэг "*Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах нэхэмжлэлийг шүүгч дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ*", 75[1].1.4 дэх хэсэгт *"бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах"* гэж хуульчилсан. Харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 82 дугаар зүйлд шүүгч дангаар хянан шийдвэрлэх хэрэг маргааныг харъяалуулан хуульчилсан бөгөөд гэм хорын хохирол нь энэ хэсэгт хамаарахгүй тул 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх хэрэг маргаанд хамаарч байгаа бөгөөд 75[1].1 дэх хэсэгт заасантай зөрчилдөж байна гэж үзэхээр байна.

Анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгийн 6-д "*Шүүх энэхүү маргааныг шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн өрөнхий зохицуулалтыг энэ маргаанд хэрэглэх шаардлагагүй гэж үзлээ. Учир нь аливаа эрх зүйн маргааныг шийдвэрлэхэд тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан тусгайлсан хууль байгаа бол түүнийг хэрэглэх зарчим үйлчилдэг...*", 6.1-д "*Ажил олгогч шимтгэл төлөх үүргээ зөрчсөнөөс ажилтанд олгогдоогүй тэтгэмжийн хохирлыг хариуцах үүргийг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.6-д тусгайлан хуульчилсан ба энэхүү нарийвчилсан хуулийн зохицуулалтыг хэрэглэх нь хууль хэрэглээний өрөнхийгөөс тусгай руу шилжих зарчимд бүрэн нийцэж байна*", 6.2-д "*Иймд уг маргаан нь хөдөлмөрийн эрх зүйн харилцаанаас үүдэлтэй бөгөөд даатгуулагчийн тэтгэмж авах эрх зөрчигдсөнтэй холбоотой байх тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1., 82.1.5-д заасан хөдөлмөрийн болон тэтгэмжийн харилцаанаас үүссэн маргаан гэх үндэслэлд хамаарч байна...*" гэж дүгнэн ердийн журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн байтал давж заалдах шатны шүүхээс ИХШХШ тухай хуулийн 75[1] дүгээр зүйлийн 75[1].1.4-т заасан *"бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах"* нэхэмжлэлд хамааруулан *шүүхийн магадлалын үндэслэх хэсгийн 4.1-д "...нэхэмжлэгч нийгмийн даатгалын шимтгэлийг төлүүлэх шаардлага гаргасан боловч энэ нь ажилтан, ажил олгогчийн хооронд үүссэн хөдөлмөрийн эрхийн маргааш биш хохирол гаргуулахтай холбоотой шаардлагын үндэслэл болсон байх тул бие даасан шаардлага гэж тодорхойлохгүй болохыг шүүх анхаараагүй байна"* гэж дүгнэсэн нь давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй тайлбарлан үндэслэлгүй шийдвэр гаргасан гэж үзэхээр байна.

Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрүүтэй тайлбарлан хэрэглэж буй Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 210/MA2026/01264 дугаар магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж өгнө үү.

Жич: Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэмэлт өөрчлөлтийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж байгаа боловч анхан болон давж заалдах шатны шүүхээс хуулийг өөр өөрөөр тайлбарлан хэрэглэж байгаад дүгнэлт хийж, хууль

хэрэглээг тогтоохоод эарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байх тул гомдлыг хүлээн авч танхимын нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Гомдол гаргасан:

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч М.Сугармаа М. Сугармаа